



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар №248

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Эрүүл мэндийн төвийн засвар (Бүрэгхангай)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Барс оргил” ХХК-тай 278,544,336 (хоёр зуун далан найман сая таван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун гучин зургаа) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д олгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Барс оргил” ХХК-ийн захирал (Б.Мөнхбаяр)-д даалгасугай.

3.Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д, хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган аймгийн Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



6326010333

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 08-ны/ний өдрийн
А/218 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Нормчлолын сан	404,093	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	4,489,917	Ү.Бямбасүрэн
3	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	19,970,000	Ү.Бямбасүрэн
4	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2,244,959	Ү.Бямбасүрэн
5	Магадлашгүй ажил	4,489,917	Ү.Бямбасүрэн
6	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн
7	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд
8	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
9	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Б.Ариунболд

--о00о--

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 08-ны/ний өдрийн
А/БНХ дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	Б.Мөнхбаяр	Ү.Бямбасүрэн
	Цахилгааны инженер	Б.Жаргалмаа, Д.Нэмэхбаяр	
	Халаалт агаар сэлгэлт, дулааны инженер	Х.Баттулга	
2	Ус хангамж ариутгах татуургын инженер	Д.Моломжамц	
3	ХАБЭА-н ажилтан	Д.Эрдэнэбулган	
4	Холбоо дохиоллын инженер	Д.Буянцогт	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Ачааны автомашин	4702БУЛ	
2	Автокран 5тн	1048СЭН	

--o00o--